

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ
ХЭЛТСИЙН ДАРГА МААМХҮҮ ОВОГТОЙ ОЮУНЧИМЭГИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Гүйцэтгэлийн түвшин			
				Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / сүүлийн хагас жилийн биелэлт/	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4		5		
НЭГ. “УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ҮНДСЭН БОЛОН ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АРГА ХЭМЖЭЭГ ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ТӨЛӨВЛӨХ, ЗОХИОН БАЙГУУЛАХ, ТАЙЛАГНАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
	Арга хэмжээ 1.1. Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх цогц арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027) боловсруулж, батлуулна.	Батлагдсан төлөвлөгөө			Цогц арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах хүрээнд: Дэд сайдаар албажсан ажлын хэсгийн үйл ажиллагааны зохион байгуулалтаар хангаж, дараах ажлыг гүйцэтгэсэн байна. • Уламжлалт анагаах ухааны Нийгмийн эрүүл мэнд, Эмнэлгийн тусламж, үйлчилгээ, санхүүжилт, Хүний нөөц, Уламжлалт эмийн чанар аюулгүй байдлын нөхцөл байдлын чиглэл бүрээр нөхцөл байдлын шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг тодорхойлж, шийдвэрлэхэд хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон. • “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын дагуу “Бодлогын баримт бичгийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ” хийсэн. • Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулсан.	01-09	50%
1			Төлөвлөгөөний төслийг батлуулсан байна.				

2024



					- Улсын Их Хурлын нийгмийн бодлогын байнгын хороонд Уламжлалт анагаах ухааны эмийн чанар аюулгүй байдлын нөхцөл байдал, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны саналыг танилцуулж, Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 71 дүгээр "Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" тогтоолыг батлуулсан. - Эрүүл мэндийн сайдын дэргэд Уламжлалт анагаах ухааны зөвлөл байгуулахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/284 дугаар тушаалаар зөвлөлийг батлуулж, төслийг зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.		
ХОЁР. "УЛАМЖЛАЛТ АНАГНААХ УХААНЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН УДИРДЛАГААР ХАНГАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
	Арга хэмжээ 2.1. УАУ-ны зонхилон тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээний зааврыг боловсруулан батлуулна.				Уламжлалт анагаах ухааны 8 заавар ("Нуугдсан халуун өвчний оношилгоо, эмчилгээний заавар", "Хий цусаар дээш хөөрөх өвчний оношилгоо, эмчилгээний заавар", "Саа өвчний оношилгоо, эмчилгээний заавар", "Хийгээр сарнисан шар өвчний оношилгоо, эмчилгээний заавар", "Бадганаар хоолой хаагдах өвчний оношилгоо, эмчилгээний заавар", "Томуу, томуу төст өвчний (дагшуур) оношилгоо, эмчилгээний заавар, Идэрчүүдийг хүчжүүлэх оношилгоо, эмчилгээний заавар, настайчуудыг шимжүүлэх оношилгоо, эмчилгээний заавар) -ын төслийг боловсруулж 5/4841, 5/..... албан тоотоор Мэргэжлийн салбар зөвлөл, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, төр, хувийн хэвшлийн уламжлалт анагаах ухааны эрүүл мэндийн байгууллагаас санал авч, 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хэлэлцүүлж, эцэслэлсэн. Газар хэлтсийн даргаар тойруулах бэлтгэл ажлыг хангаж байна.		
2		Батлагдсан тушаал		УАУ-ны 8 өвчний оношилгоо, эмчилгээний зааврыг боловсруулан батлуулсан байна.	Уламжлалт анагаах ухааны 8 заавар ("Нуугдсан халуун өвчний оношилгоо, эмчилгээний заавар", "Хий цусаар дээш хөөрөх өвчний оношилгоо, эмчилгээний заавар", "Саа өвчний оношилгоо, эмчилгээний заавар", "Хийгээр сарнисан шар өвчний оношилгоо, эмчилгээний заавар", "Бадганаар хоолой хаагдах өвчний оношилгоо, эмчилгээний заавар", "Томуу, томуу төст өвчний (дагшуур) оношилгоо, эмчилгээний заавар, Идэрчүүдийг хүчжүүлэх оношилгоо, эмчилгээний заавар, настайчуудыг шимжүүлэх оношилгоо, эмчилгээний заавар) -ын төслийг боловсруулж 5/4841, 5/..... албан тоотоор Мэргэжлийн салбар зөвлөл, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, төр, хувийн хэвшлийн уламжлалт анагаах ухааны эрүүл мэндийн байгууллагаас санал авч, 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хэлэлцүүлж, эцэслэлсэн. Газар хэлтсийн даргаар тойруулах бэлтгэл ажлыг хангаж байна.	01-12	50% 
3	Арга хэмжээ 2.2. Монгол Солонгосын дорнын анагаах	Холбогдох тушаал шийдвэрт		Монгол Солонгосын дорнын анагаах	Төрийн нарийн бичгийн даргын А/43 дугаар тушаалаар Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн удирдлага, зохион байгуулалт,	01-12	100%



	ухааны төвийн харьяалал статусыг асуудлыг шийдвэрлэнэ.	тусгасан тайлан		ухааны төвийн харьяалал статусын асуудал шийдвэрлэгдсэн байна.	тусламж, үйлчилгээ, санхүүжилтийн үйл ажиллагаатай танилцаж, өмчлөл, ОУ-ын гэрээний биелэлтэд хяналт тавьж, тус төвийн нөхцөл байдлын судалгааг гарган Төрийн нарийн бичгийн даргад танилцуулсан. Тус үнэлгээний үр дүнд МСДАУТ-ийн өмчийн маргаантай (газар) асуудлыг шийдвэрлэсний дараа харьяалал, статусыг шийдвэрлэхээр болсон. Тус үйл ажиллагааны хэрэгжилтийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тайлагнаж, Эрүүл мэндийн яамны талаас холбогдох арга хэмжээг авсан байна гэж дүгнэдсэн. Цаашид газрын маргаантай асуудлыг ТӨБЗГ-т холбогдох материалыг ирүүлж хамтран шийдвэрлэх чиглэл өгсний дагуу 2/4872 тоот албан бичгийг холбогдох материалын хамт хүргүүлсэн.		
4	Арга хэмжээ 2.3. УАУ-ны нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрхзүйн орчин бүрдүүлнэ.	Боловсруулж хүргүүлсэн санал		УАУ-ны нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцын саналыг боловсруулж холбогдох газар хүргүүлсэн байна.	Уламжлалт анагаах ухааны аргаар нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, багцыг боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлон Нийтийн эрүүл мэндийн газар, ажлын хэсэгт өгсөн.	07-12	100%
5	Арга хэмжээ 2.4. УАУ-ыг ард иргэдэд сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулна.	Үйл ажиллагааны тоо-1		УАУ-ыг ард иргэдэд сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулсан байна.	Эрүүл-мэндийн-сайдын 2024 оны А/340-дүгээр "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаалаар "Нүүдэлчин" Дэлхийн соёлын фестивальд уламжлал анагаах ухааны үзэсгэлэн байгуулж оролцох бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэг байгуулсан. Тус фестивалд Уламжлалт анагаах ухаан өргөө барьж, Сэрээнэн оточийн эдэлж хэрэглэж байсан гэр үзэсгэлэнг гаргаж оролцсон. Мөн уламжлалт анагаах ухааны аргаар өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтууд, эмийн түүхий эдийг бэлтгэх түгээхэд анхаарах асуудал, уламжлалт анагаах ухааны түүх судлалын чиглэлээр илтгэл мэдээллийг ард иргэдэд	07-12	100%

2024

					танилцуулж, санал хэлэлцүүлж, зохион байгуулсан.		
6	Арга хэмжээ 2.5. УАУ-ны эмнэлгийн тусламж, үйлчилгээний анхан шатны бүртгэлийн маягтыг шинэчлэх саналыг боловсруулж, хэлэлцүүлнэ.	Боловсруулсан санал	ЭМС-ын А/611 дүгээр тушаалаар батлагдсан УАУ-ны бүртгэлийн маягт	УАУ-ны эмнэлгийн тусламж, үйлчилгээний анхан шатны бүртгэлийн маягтыг шинэчлэх саналыг боловсруулж, ЭМХТ-д албан бичгээр хүргүүлсэн байна.	Уламжлалт анагаах ухааны эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор, мэргэжилтнүүдийг саналыг авч, хэлэлцүүлэн дараах журам, маягтыг өөрчлөх саналыг боловсруулан 2024 оны 5/830 дугаар албан бичгээр Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлсэн. Тодруулбал, - Тусламж, үйлчилгээг бүртгэх мэдээлэх журамд өөрчлөлт оруулах санал - Эрүүл мэндийн бүртгэлийн болон тайлангийн маягтын төсөл - Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд хөтлөх бүртгэлийн маягтын төсөл Дээрх саналууд ЭМС-ын А/611 дүгээр тушаалын шинэчлэлийн хүрээнд батлагдаагүй ч цахимын программ-д өөрчлөлтүүд орж эхлээд байна.	02-04	100% 30%
7	Арга хэмжээ 2.6. Уламжлалт анагаах ухааны хүний нөөцийн чадавхыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулна.	Зохион байгуулсан арга хэмжээний тайлан		Уламжлалт анагаах ухааны хүний нөөцийн чадавхыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулсан байна.	Эрүүл мэндийн сайдын 1а/258 дугаар албан бичгээр хүргүүлсэн саналыг хэрэгжилтийг хангах хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/166 дугаар тушаалаар "Уламжлалт анагаах ухааны сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөрийн чанарыг сайжруулах, түүнд ажиллаж буй хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, дараах үр дүнг гаргасан. "УАУ-ы их эмчийн бакалаврын хөтөлбөрт тавих тусгай шаардлагыг сургалт эрхлэх байгууллагын төлөөлөл хамтран боловсруулж, зөвшилцөлд хүрч, БШУС-ын А/147 дугаар тушаалаар батлагдсан Дээд боловсролын	01-12	100%

8/15

					сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагад "УАУ-ны хөтөлбөрийн мэргэжлийн суурь, мэргэших хэсгийн багц цагийн 60-аас доошгүй хувь нь уламжлалт анагаах ухааны агуулга байна" гэж, "..... Анагаах ухаан, нийгмийн эрүүл мэнд, эм зүй, нүүр ам судлалын хөтөлбөрт уламжлалт анагаах ухааны 4-өөс доошгүй багц цагийн агуулгыг заавал судлахаар тусгана." гэж тусгайлсан заалтыг оруулсан. - УАУ-ны их эмч хөтөлбөрийн суралцахуйн цогц чадамжийн хүрээг боловсруулсан. - Уламжлалт анагаах ухааны хүний нөөцийг сургах, чадавхжуулахад бодлогын түвшинд дэмжин хэрэгжүүлэх 28 үйл ажиллагааг тодорхойлж, богино хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг боловсруулж гаргасан.		
ГУРАВ. " УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ЗАСАЛ, ЭМИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
8	Арга хэмжээ 3.1. Эмийн бүртгэлийн шинжээч ажиллуулах журамд УАУ-ын шинжээчийн шалгуур хуудсыг боловсруулж, ЭЭХХЗГ-г хүргүүлнэ.	Хүргүүлсэн албан бичиг	ЭЭХХЗГ-ын даргын 2022 оны А/233 дугаар тушаал	Эмийн бүртгэлийн шинжээч ажиллуулах журамд УАУ-ын шинжээчийн шалгуур хуудсыг боловсруулсан байна.	Уламжлалт эмийн үндэсний үйлдвэрийн шинэ эмийн бүртгэлийн эмзүйн болон эмнэлзүйн шинжээчийн үнэлгээний хуудсыг шинээр боловсруулж, ЭЭХХЗГ-т 2024 оны 05/2526 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	01-06	100%
9	Арга хэмжээ 3.2. Зайлшгүй шаардлагатай уламжлалт эмийн жагсаалтыг боловсруулж батлуулна.	Батлагдсан тушаалын тоо-1		Зайлшгүй шаардлагатай уламжлалт эмийн жагсаалтыг боловсруулж батлуулсан байна.	Уламжлалт анагаах ухааны зонхилон тохиолдох өвчинд хэрэглэгддэг 108 эмийн жагсаалт боловсруулсан, үүнээс зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг гаргахад чиглэн шаардагдах баримт бичгийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч байна.	01-12	30%
10	Арга хэмжээ 3.3. Уламжлалт эмийн олгох нөхцөлийн жагсаалт гаргаж, заавар батлуулна.	Батлагдсан тушаалын тоо-1		Уламжлалт эмийн олгох нөхцөлийн жагсаалт, зааврын батлуулсан байна.	Уламжлалт эмийн олгох нөхцөлийн зөрчлийг арилгах хүрээнд улсын бүртгэлд бүртгэгдсэн 457 уламжлалт эмийн олгох нөхцөлд үнэлгээ хийж, 52 эмийн олгох зөрчлийг илрүүлж, Уламжлалт эмийн зохистой хэрэглээ, аюулгүй байдлыг хангахад чиглэн эрдэмтэн, судлаачид хамтран эх сурвалж	01-12	70%

419

				болон судалгааны мэдээлэлд үндэслэн гаргасан 109 жорыг лавлахад үндэслэн 117 уламжлалт эмийн олгох нөхцөлийг ялгамжааг тодорхойлж, жагсаалтаар гарган, эмийн бүртгэл, олгох нөхцөлийг баталгаажуулахад ашиглах саналыг 2024 оны 5/5004 албан бичгээр Эм, эмнэлгийн хэрэгслийн газарт хүргүүлсэн. Эм, эмнэлгийн хэрэгслийн шинэчилсэн хуулийн зохицуулалтаар үйлдвэрлэгч эмийнхээ олгох нөхцөлийг олон улсын болон үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүлэлд нийцүүлэн тодорхойлж, бүртгүүлэх зохицуулалттай тул олгох нөхцөлийн зааврыг тушаалаар батлах шаардлагагүй болсон.			
ДӨРӨВ “УЛАМЖЛАЛТ ЭМ, ЭМИЙН ТҮҮХИЙ ЭД, ЗАСАЛ ЭМЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, УАУ-НЫГ ОРЧИН ЦАГИЙН АНАГААХ УХААНТАЙ ХОСЛУУЛАН ХӨГЖҮҮЛЭХ УЯЛДАА, ХОЛБООГ ХАНГАХ ТАЛААР БОДЛОГЫН ХҮРЭЭНД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨЛӨВЛӨЖ, ЗОХИОН БАЙГУУЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
	Арга хэмжээ 4.1. Уламжлалт эмийн фармакопейн ерөнхий өгүүллийн төслийг боловсруулж, батлуулна	Батлуулсан фармакопейн тоо-20		Уламжлалт эмийн 20 фармакопейн ерөнхий өгүүллийн төслийг боловсруулсан байна.	Уламжлалт эмийн хэлбэрээр фармакопейн 8 (талх, тан, үрэл, ханд, архин, тосон, үнсэн, зуурмал) эмийн хэлбэрээр тавигдах ерөнхий шаардлага өгүүлэлд Фармакопейн хорооноос өгсөн санал, зөвлөмжийг тусгах хүрээнд Мэргэжлийн салбар зөвлөл, мэргэжлийн нийгэмлэг, холбоод, эмийн үйлдвэр, эмийн төлөөлөлтэй уулзалт хийж төслийг эцэслэн фармакопейн хороогоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангасан. Шинэчилсэн “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай” хуулийн 19.4. “Дотоод болон гадаадын ерөнхий нэршлийн эмийн чанар, аюулгүй байдлыг шинжлэхэд олон улсад зөвшөөрөгдсөн фармакопейг ашиглана”, 19.5. “Дотоодын үйлдвэрийн анхдагч эм, ургамлын гаралтай эм, тэдгээрийн түүхий эдийн чанар, аюулгүй байдлыг шинжлэхэд Фармакопейн хороогоор батлагдсан үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүллийг ашиглана.” гэж тусгагдан батлагдсантай холбогдуулан уламжлалт эмийн үндэсний фармакопейн өгүүлэл боловсруулан батлуулахад үндэслэх эрхзүйн орчингүй болсон.	01-12	70%

Q

Q

Q

ТАВ. "УЛАМЖЛАЛТ ЭМ, ЭМИЙН ТҮҮХИЙ ЭД, ЗАСАЛ ЭМЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР САЛБАР ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
12	Арга хэмжээ 5.1 Уламжлалт анагаах ухааны түгээмэл үйлдлийн стандартыг боловсруулж, батлуулах арга хэмжээг авсан байна.	Батлагдсан стандартын тоо-10		Түгээмэл үйлдлийн стандартын төслийг боловсруулж батлуулсан байна.	Уламжлалт анагаах ухааны засал эмчилгээний 18 үйлдлийн стандартын төслийг боловсруулж, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагаас 5/4811 албан бичгээр санал авч, нэгтгэн хэлэлцүүлж, Стандарт хэмжил зүйн газарт батлуулахаар 5/5086 албан бичгээр хүргүүлсэн.	01-09	90%

ХОЁР. НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР(арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Нэмэлт, өөрчлөлт орсон арга хэмжээ 1. "Процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээ хийх баг"-т томилогдон ажиллах			"Процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээ хийх баг"-т ажилласан байна.	1. Эрүүл мэндийн яамнаас томилогдон "Процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээ хийх баг"-т 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөс 5 долоо хоног ажиллаж, тус судалгаа, шинжилгээний ажлын хүрээнд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар ажиллаж даалгасан чиглэлийн дагуу судлан тайлан мэдээллийг гаргаж өгсөн. 2. Мөн 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 2 долоо хоногийн хугацаанд ЗГ-ын ХХГ-т ТО-ВЕ багт ажилласан.	03-06	100%
2.	Нэмэлт, өөрчлөлт орсон арга хэмжээ 2. Эрүүл мэндийн яамны өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулсан байна.			Яамны "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн үйл ажиллагааг	Яамны "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн даргаар ажиллаж дараах үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд: • ТӨБЗГ-ын 2023 оны 773 дугаар "Шалгалтын мөрөөр авах арга	03-06	100%

216



Д/д	Үүрэг дотгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Сүүл түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
				удирдан зохион байгуулна.	хэмжээний тухай" тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд төлөвлөгөө боловсруулж, хариуг хугацаанд нь хүргүүлсэн. • Эрүүл мэндийн яамны Өмч хамгаалах байнгын зөвлөлийн бүрэлдэхүүн баталсан тушаалын шинэчлэн батлуулсан. • Өмч хамгааллын байнгын зөвлөлийн ээлжит хурлыг зохион байгуулж, шийдвэр гарган баталгаажуулсан. • Эрүүл мэндийн яамтай байгуулсан төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай хийсэн гэрээний хэрэгжилтийг үнэлүүлж 85%-тай үнэлэгдсэн. • Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр гүйцэтгэлийн хяналт шалгалтын удирдамжийн дагуу ТӨБЗГ-ын 2023 оны 773 дугаар тогтоолын хэрэгжилтийг хяналтын хуудсын асуулгын дагуу ӨХБЗ-ийн үйл ажиллагааг тайлагнаж гүйцэтгэл 90% тай хамгаалсан		
3	Нэмэлт, өөрчлөлт орсон арга хэмжээ 3. Үнэлгээний хороог даргалах үүрэг: 1. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын А/121 дүгээр тушаалаар батлагдсан. МУ-д КОВИД- 19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн хүрээнд	Захиалагчид санал, дүгнэлтийг хүргүүлсэн байна.		Хуулийн дагуу үнэлгээний хорооны үйл ажиллагааг удирдан зохион байгуулсан байна.	Үнэлгээний хорооны даргаар ажиллаж, гишүүдийг удирдлага, зохион байгуулалтаар ханган, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг хийн, захиалагчид санал, дүгнэлтийг хуулийн хүрээнд хугацаанд нь хүргүүлсэн.	03-06	100%

417

Д/д	Үүрэг дорлгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Сүүл түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
	"Ковид-19 төслийн үр өгөөж, сургамж, сайн туршлага зэрэг сэдвээр видер материал бэлтгэх" гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хорооны дарга 2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын А/121 дүгээр тушаалаар батлагдсан. "Гарын авлага заавар, зөвлөмж, зэрэг мэдээлэл, сургалт сурталчилгааны материал хэвлэх" гүйцээтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны дарга 3. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/27 дугаар тушаалаар батлагдсан Хөвсгөл аймгийн Сумын эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай тоног төхөөрөмжийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах "Үнэлгээний хороо—ны дарааг ажилласан.						
4	Ерөнхийлөгчийн эмч томилох тушаалыг боловсруулж, батлуулсан.				Албаны нууцын түвшинд Ерөнхийлөгчийн эмч томилох тушаалыг боловсруулж, батлуулсан.	10	100%
5	Багийн эмчийн зөвлөгөөн"-ий зохион байгуулалт, багийн эмчийн онлайн судалгаа хийж, зөвлөгөөний тайланг гаргасан.	Зөвлөгөөн зохион байгуулсан байна.		Зөвлөгөөн зохион байгуулсан байна.	"Багийн эмч нарын зөвлөгөөн"-ийг 2024 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Тус зөвлөгөөний бэлтгэл ажлын хүрээнд удирдамж, төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж батлуулсан. Багийн эмчийн нийгмийн байдал, тулгамдаж байгаа асуудлыг	10	100%

2024

Д/д	Үүрэг дэглгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
					тодорхойлох, санал бодлогыг нь цуглуулах онлайн асуумж, судалгааг авах бэлтгэл ажлыг хангаж, судалгааны мэдээлэлд боловсруулалт хийж, Багийн эмчийн зөвлөгөөнд танилцуулсан. Мөн тус зөвлөгөөнөөр хөндөгдсөн тулгамдсан асуудлыг нь шийдвэрлэх хүрээнд орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтныг нийслэлд төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээнд шуурхай хамруулах зорилгоор тусгайлсан зохицуулалтыг гарган төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг болон орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад 1а/4625 албан бичгээр чиглэл хүргүүлсэн. Зөвлөгөөний хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан мэдээллийг нэгтгэсэн.		

#1370
4440

598 881/.

ГУРАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Арга хэмжээ 1. Уламжлалт анагаах ухааны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний	Тайлан		Уламжлалт анагаах ухааны эрүүл мэндийн	Уламжлалт анагаах ухааны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нөхцөл байдлын мэдээллийг гарган	01-12	100%

299


	чиглэлээр тоон мэдээллийн судалгаа гаргах, нөхцөл байдал төлөв байдлыг тодорхойлж, тайлан мэдээллийг бэлтгэж удирдлага болон холбогдох байгууллагыг мэдээллээр хангана.			тусламж, үйлчилгээний чиглэлээр тоон мэдээллийн судалгаа гаргах, нөхцөл байдал төлөв байдлыг тодорхойлсон байна.	илтгэл мэдээлэл бэлтгэн удирдлагуудыг ханган ажиллаж байна. • Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс өгсөн үүргийн дагуу 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Уламжлалт анагаах ухааны нөхцөл байдлын мэдээлэл, илтгэлийг танилцуулсан. • Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөө, салбарын хяналтын үндэсний зөвлөгөөнд Эмнэлгийн тусламжийн газрын илтгэлд УАУ-ны мэдээллийг оруулсан. • Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороонд УАУ-ны тусламж үйлчилгээний нөхцөл байдлын мэдээллийг танилцуулсан. • Бутаны Хаант Улсын Цог Жавхлант Хаан Жигмэ Гэсэр Намжил Ванчук-ийн 2024 оны 7 дугаар сард Монгол Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр “Уламжлалт анагаах ухааны салбарт хамтран ажиллах тухай” Монгол Улсын Эрүүл мэндийн яам, Бутаны Хаант Улсын Эрүүл мэндийн яам хооронд харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг боловсруулж байгуулсан.		
2	Арга хэмжээ 2. Албан тушаалын онцлогт нийцүүлж, зайлшгүй шаардлагатай ур чадварыг дээшлүүлэх мэргэжлийн сургалтад хамрагдана.	Сургалтад хамрагдсан батламж		ТОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтад	Эрүүл мэндийн яамны ТНБД-ын А/54 дүгээр тушаалаар “Сургалтад хамрагдах албан хаагчдын нэрс”-д тусгагдсаны дагуу ТОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтад хамрагдаж	03-12	100%



				хамрагдаж гэрчилгээ авсан байна.	2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн шалгалтанд тэнцэж гэрчилгээ авсан.		
3	Арга хэмжээ 3. Удирдлагаас өгсөн үүргийн дагуу ажлын хэсэг, зөвлөл, үнэлгээний хороонд ажиллана.	тайлан		Удирдлагаас өгсөн үүргийн хэрэгжилтийг хангасан байна.	- Төрийн нарийн бичгийн даргын А/27 дугаар тушаалаар байгуулагдсан "Эмнэлгийн тоног, төхөөрөмж /Хөвсгөл/ төсөл, арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны даргаар ажиллаж үнэлгээний хорооны зөвлөмжийг захиалагчид хүргүүлсэн. "Эмч нарын баяр", "Сувилагчийн баяр", "Салбарын хяналтын үндэсний зөвлөгөөн"-ий хурлын ЭТГ-ын даргын илтгэл бэлдсэн. - ЭМС-ын 2024 оны А/179 дүгээр тушаалаар Дорнод аймгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр батламжлагдсаны дагуу Зөвлөлийн зохион байгуулалтын үйл ажиллагааг ханган ажиллаж байна.	01-12	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ХЭЛТСИЙН
ДАРГА
(Албан тушаал)

 /М.ОЮУНЧИМЭГ/
(Нэр, гарын үсэг)

2024.12.04
(Огноо)

100

